

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дамдинсүрэн	Дугаар	L127
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Мөнхаан
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Боонгийн хийд, Өндөр Майдарын хийд, Цагаанчулуутын хийд	Сүм хийдийн дугаар	СБМХ 052, СБМХ 062, СБМХ 051
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 11	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Сүхбаатар аймгийн Мөнхаан сумын Боонгийн хийд, Өндөр Майдарын хийд, Цагаанчулуутын хийд

-Настай улсуудтай уулзаж хуучин сүм хийдийн талаарх мэдээлэл цуглуулж явна. Та нутаг орондоо байсан өөрийн мэдэх сүм хийдийн тухай ярьж өгнө үү?

Би уг нь энэ нутгийн хүн биш. Боонгийн хийд гэж байх нь байсан гэж ярьдаг. Суварга байсан гэдэг. Энэ урд. Дээр, хувьсгалын үед тэр суваргыг нураачихсан юм байна лээ. Энэ жил тэрийг сэргээгээд суварга босгоод байгаа юм.

-Энэ суварга ямар учиртай юм бэ? Хэлмэгдсэн лам нарынхаа дурсгалд зориулж босгосон юм уу, уул овоондоо босгосон юм уу?

Одоо юу юм бол доо. Овоо ууландаа босгосон байх. Буйан хишгээ тогтоож овоо босгож байгаа юм л гэсэн. Тэр урд хийд гэдэг чинь юу гэдэг юм бол доо. Тэрийг чинь манай ах л сайн мэднэ дээ. Мөнхаан дээгүүр орвол Дүгэрсүрэн гэдэг хүнийг сураад очвол яг энэ урд суварганы чигийн хүн шүү дээ. Тэр Боонгийн хийдийн чинь дэргэд бараг төрсөн хүн. Миний ах болох хүн байгаа.

-Тэр хүн багадаа хуралд сууж байгаагүй юу?

Суугаагүй. Төрсөн нутаг нь яг тэр Боонгийн хоолойд чинь.

-Зүрхийн хоолой гэдэг хаашаа байдаг газар вэ?

Зүүн хойшоо. Тэр цагаан Овооийн хийд гэдэг ямар учиртай юм?

Цагаан чулуутын хийд гэдэг чинь. Цагаан чулуун сүм гэдэг чинь тэрийг хэлж байгаа юм. Хийдтэй газар байсан гэж байгаа юм л даа. Суурь нь байгаа.

-Боонгийн хоолойд өөр хийд байсан үү?

Өөр юм байгаагүй байх. Би мэдэхгүй байна. Байхгүй байх аа.

-Боонгийн хийд гэдэг нь Цагаан чулуутын хийдээсээ урагшаа байсан хийд үү?

Тийм. Цагаанчулууны булаг гээд жаахан цагаан толгойн дэргэд нь айл байгаа. Хийд нь урдхан нь байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Боонгийн хийдийн тухай хууччуулаас сонссон дуулсан юм юу байна? санаж байгаа юм юу байна?

Тийм юм ч одоо байхгүй байна. Мэдэх хүн ч алга болоод байна. Ангалгийн Наваан гэдэг хүн байсан. Тэр одоо байхгүй. Лам байсан хүн.

-Баянтэрэм сумын Өндөр Майдарын хийдийн тухай?

Өндөр Майдарын хийд гэж байсан нь ч байсан л юм гэсэн. Сүүлд баларсны дараа нь Худалдаа бэлтгэлийн анги дуганд нь байж л байсан л даа.

-Баянтэрэмийн төв дээр байсан уу?

Тийм. Тэр олон барилганы чинь орон дээр л байсан л даа. Сумын худалдаа бэлтгэлийн ангийн бараа агуулж байсан газар шүү дээ.

-Яг дуган дотор нь уу?

Тийм.

-Өндөр Майдарын хийд маань хэдэн дугантай, хэр олон ламтай газар байсан юм бэ?

Одоо мэдэхгүй юм. Хамгийн сүүлд хэдэн онд тэр дуган нь байж байсан бэ?

Намайг л сургуульд ороход буулгаагүй л байсан. Би 1939 онд сургуульд орсон.

-Тэр үед хэдэн дуган байсан бэ?

Байх нь байсан. Мэдэхгүй. Өндөр Майдарын хийд гэж байх нь байсан юм аа.

-Зүүн Ганжуурын хийд гэж хаана байсан юм бэ?

Тэр чинь одоо мэдэхгүй хаана байсан юм бол доо.